



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №15


2019 оны 5 дугаар сарын 06-10

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 439 яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 80(18.2%) галзуугийн эрсдэлд өртсөн, 346(78.8%) хачигт халдвар, 4(0.9%) боом, 3(0.6%) тарваган тахал, 2(0.4%) хумхаа, 1(0.7%) ям, 2(0.4%) денги, 1(0.4%) бэтэг өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Сүхбаатар аймгийн 91 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 346 сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 28.7%-иар, эпидемиологийн 18 дугаар долоо хоногтой харьцуулахад 23 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.



Он гарсаар хачигт риккетсиозын 297 сэжигтэй тохиолдлын 17(5.7%), хачигт боррелиозын 34 сэжигтэй тохиолдлын 3(8.8%), хачигт энцефалитын 15 сэжигтэй тохиолдлын 1(6.6%) нь тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдсан.

1.2 Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 22 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт нийт 80 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 43%-иар, эпидемиологийн 18 дугаар долоо хоногтой харьцуулахад 4 тохиолдлоор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл: эзэнтэй нохойд (36.2%), чононд (22.5%) эзэнгүй нохойд (13.8%), үнэгэнд (10%), үхэрт (5%), мануулд (3.8%), мууранд (2.5%), тэмээнд (1.3%) нь уруулж, ноцуулж вакцин, ийлдэс эмчилгээнд хамрагдсан.



1.3 Тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:


Увс аймгийн Улаангом сумаас тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдсэн. Молекул биологийн шинжилгээний дүнгээр тарваган тахлын үүсгэгч өвөрмөц ДНХ тодорхойлогдоогүй байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ


Олон улсад:

Эбола вирус халдвар:

2019 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вирус халдварын сэжигтэй тохиолдол 1495 тохиолдол бүртгэгдэж, үүнээс 984 (66%) нь нас барсан. Нийт тохиолдлын 830 (56%) нь эмэгтэйчүүд, 422 (28%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзэлж байна.



Зураг 1. Эпидемиологийн долоо хоногоор



Зураг 2. Эбола вирус халдварын тархалт, БНАК улс

Эх сурвалж: ДЭМБ

Адууны ханиад:

Итали улсын Мал амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 4 дүгээр сарын 03-нд Молисе хотын нэгэн бүс нутгийн аж ахуйд адууны ханиад бүртгэгдэж, 1 адуу өвчилсөн байна.

Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.




Эх сурвалж: ДМАЭМБ

Шүлхий өвчин:

Изриаль улсын Мал амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 5 дугаар сарын 02-нд Хайфа тосгонд шүлхий өвчин бүртгэгдэж 69 адуу өртөмхий байснаас 3 нь өвчилсөн байна.

Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ